



**ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН “ОЮУНЫ УУРХАЙ”
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/15

Бор-Өндөр сум

Багш нарт мэргэшлийн зэрэг олгох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.5 дахь заалт, 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчдад мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”, Боловсролын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/95 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам”-ын 3.1, 3.2.1, 4.1.1, 4.10.1, 4.21 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Мэргэшлийн зэргийн шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан бага ангийн багш А.Халиун, Д.Цовоо нарт “Заах аргач” мэргэшлийн зэрэг тус тус олгосугай.

2.Мэргэшлийн зэрэг шинээр авсан багш нарт мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сар бүр бодож, олгохыг нягтлан бодогч (Б.Анхчимэг)-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.АМАРЖАРГАЛ